

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2019 ОНЫ  
253 ДУГААР ТУШААЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ДАЛАЙН ЗАХИРГААНААС ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Хэрэгжүүлэх заалт	Хэрэгжилтийн байдал
1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль түүнийг дагаж гарсан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах, удирдлага, зохион байгуулалт, хариуцлага хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:	Ажилтнуудын саналд үндэслэн боловсруулсан ажлын байр тус бурд тохирсон аюулгүй ажиллагааны зааварчилгаануудыг өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Далайн захиргааны даргын баталсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох журмуудын хэрэгжилтэд байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөл болон Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс хяналт тавин ажиллаж байна. Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв зардлыг байгууллагын 2022 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусган батлуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.
2. Байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажиллагдын тооноос хамаарч Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, бүтэц орон тоог бий болгох чиглэлээр:	Далайн захиргааны 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 88 дугаар тушаалаар байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүний шинэчлэн байгуулж, зөвлөлийн ажиллах журамд зарим нэмэлт өөрчлөлтийг оруулаад байна. Түүнчлэн Далайн захиргаа орон тооны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болохоор төлөвлөж, саналаа байгууллагын дүрэм болон бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэх төсөлд тусган ЗТХЯ-нд хүргүүлсэн.
3. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангарт, чанар, хэрэглээнд шалгалт хийж хяналт тавих, аюулгүй байдлын самбар, санамжуудыг шинэчлэх, шинээр байрлуулах чиглэлээр:	Далайн захиргааны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл нь ажлын байранд болон Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн хяналтын байрууд, усан зогсоолд байрлуулсан аюулгүй ажиллагааны санамж бүхий самбуруудын ашиглалтад тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд энэ онд шинээр нэмж самбар байрлуулаагүй болно. Далайн захиргааны даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 89 дүгээр тушаалаар томилсон комиссын Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн "Хяналтын пост"-д 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр хийсэн ХАБЭА-н 2 дугаар шатны үзлэгээр усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд ажлын хувцас, хяналтын завинуудын аврах хантаазны ашиглалтад хяналт тавин ажилласан. Энэхүү үзлэгээр улсын байцаагчид ажил үүргээ гүйцэтгэхэд зориулалтын борооны цув, усны гутал байхгүй, аврах хантаазны тоо хангалтгүй, мөн бус бэхэлгээ, түгжээ нь зөвдэрч муудсан зэрэг ашиглалтын шаардлага хангахгүй гэж үзэж, зөрчлийг арилгах талаар хариуцсан ажилтанд үүрэг болгосон.

4. Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгалт авч, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дадлыг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх чиглэлээр	<p>Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажил олгогчид болон албан хаагчдад зориулсан ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандартын мэдлэгийг дээшлүүлж, ажлын байрны аюулгүй ажиллагааг сайжруулах, зөв хандлагыг бий болгох зорилготой сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, нийт 23 албан хаагчид оролцлоо.</p> <p>Ажил олгогчийн сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчныг бүрдүүлэх, сөрөг хүчин зүйлийг бууруулах талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ХАБЭА-н суурь болон хууль эрх зүйн ойлголт, MNS ISO45001:2018 стандартын ойлголт ба ажил олгогчийн манлайлал сэдвүүд багтсан.</p> <p>Нийт албан хаагчийн сургалтын хөтөлбөрт эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй орчинд ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд ХАБЭА-н талаар суурь мэдлэг олгох, хууль эрх зүйн ойлголтыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм, анхаарах асуудал, ажлын байрны эргономик, онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшигийн бэлэн байдал, осолд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж үзүүлэх талаарх үндсэн мэдлэгийг олгох сэдвүүд багтсан.</p>
5. Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, байгууллагын эмчийн ажиллах нөхцөл, өрөөний тохиижилтийг сайжруулах чиглэлээр:	<p>Далайн захиргааны нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлөөс жил бүр зохион байгуулж хэвшсэн. Энэ жил "Териийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг"-тэй хамтран Далайн захиргааны нийт албан хаагчид болон ахмад ажилтнуудыг оролцуулан 29 хүнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулав.</p>
6. Хортой нөхцөлд ажиллаж байгаа ажлын байранд хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн судалгаа хийж дүгнэлт санал боловсруулж танилцуулах чиглэлээр	<p>Далайн захиргааны ажлын байрууд нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлд хамаарагдаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд гарсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй болно.</p>
<p><b>"Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:</b></p>	
1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг жил бүр төсөвт тусган зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавих;	<p>ХАБЭА-н хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбоотой зардлын төсвийг байгууллагын 2021 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусган батлуулсан.</p> <p>Төсөвлөсөн зардлаас 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар дараах ажлуудад нийт 45 сая гаруй төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавин</p>

	<p>ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдад дархлаажуулах, ариутгал халдвартгүйжүүлэх зардал;</li> <li>- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сарын аян-2022” сарын аян зохион байгуулах;</li> <li>- ХАБЭА-н хууль, тогтоомжийн сургалтад ажил олгогчийг болон нийт албан хаагчдыг хамруулах;</li> <li>- ХАБЭА-н 2 дугаар шатны үзлэгийг зохион байгуулах Ажлын хэсгийн томилолтын болон үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах;</li> <li>- Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах;</li> <li>- Далайн захирагааны оффисын болон усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийлгэх;</li> <li>- Ажлын байрны онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх дадал олгох сургалтад зарим албан хаагчдыг хамруулах;</li> <li>- Албан хаагчдыг эрүүл мэндэд анхаарч, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийлгэх, чийрэгжүүлэх;</li> </ul>
1.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үзлэг, хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулсан байх;	<p>Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн хяналтын постын байранд Далайн захирагааны даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 89 дүгээр тушаалаар томилсон Комисс 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр хийсэн ХАБЭА-н 2 дугаар шатны үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хяналтын байр, ажилчдын байрны цонх болон гаднах хаалганы эвдэрсэн цоож, бариул сольсон. Энэ нь дотор талаасаа хааж, нээхэд маш хүндрэлтэй байсан.</li> <li>- Хяналтын байрны /гарааш/ зогсоолд хадгалж байсан эд хогшил, сэлбэг хэрэгслийн хадгалалтын шаардлага хангахгүй, эмх замbaraагүй хураасан байсныг цэгцэлж, агуулахын зориулалттай төмөр тавиуруудтай болгосон.</li> <li>- Хяналтын постын гадна цахилгааны шугамын 2 шон сууриараа хазайсныг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр засварыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Цаашид дахин хазайх эрсдэлийг бууруулах үүднээс шонгийн гадна талаар хашлага, хаалт хийлгэх шаардлагатай байгаа.</li> <li>- Ариун цэврийн байгууламжийн барилгын дээврийн засварын ажилд болон ажилчдын байранд гал тогооны шүүгээ, тавиур хийхэд шаардлагатай материалыг худалдан авсан.</li> <li>- Хяналтын постын хашаан доторх гэрэлтүүлгийг нэмсэн.</li> <li>- Хүйтний улиралд ашигладаг нүхэн жорлонгийн бохирыг хөрсөнд шингээдэггүй битүүмжлэлтэй, 3 тонны багтаамжтай зориулалтын бохирын сав суурилуулсан.</li> </ul>

<p>2. Энэхүү тушаалын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван /3/ шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас жил тутамд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд тайлагнаж байхыг харьяа байгууллагын дарга нарт;</p>	<p>Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн хяналтын постын байранд 2022 онд ХАБЭА-н 2 дугаар шатны үзлэг, шалгалт явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор Далайн захиргааны даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 89 дүгээр тушаалаар томилсон комисс 2022 оны 09 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд ажилласан тухай ажлын тайланг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, Зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хорооны даргад 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдөр 1/293 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>
---	--

#### ДАЛАЙН ЗАХИРГАА